

Нэгдүгээр хэсэг. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавар, нийт 76 оноотой. Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн 1 хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. Хариултын хуудасны заавартай уншиж танилцаарай. Амжилт хүсье.

1. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Нарийн голын хөндийн оршин суугчдын эрхэлж байсан аж ахуй аль нь вэ? (1 оноо)
 А. Олзворлох, түүвэрлэх аж ахуй В. Ан агнуурын аж ахуй С. Мал аж ахуй
 D. Тариалангийн аж ахуй E. Үйлдвэрлэх аж ахуй
2. Эртний хүмүүс хатуу цахиурлаг чулуугаар хийсэн гилбэр зэвсгийг ямар зориулалтаар ашиглаж байсныг зөв тодорхойлно уу. (2 оноо)

1. Мах огтлох, зүсэх	2. Том амьтдыг агнах	3. Зүймэл зэвсэг хийх
4. Жад хийх	5. Яс хугачих	
A. 1,4	B. 1,5	C. 2,4
		D. 3,5
		E. 2,3

3. Гадаргууг нь мөлийлгөн өнгөлсөн нарийн хийцтэй чулуун сүх бий болсон нь аль үед холбогдох вэ? (1 оноо)
 А. Доод палеолит В. Дээд палеолит С. Мезолит D. Энеолит E. Неолит

4. Цэгийн оронд тохирох утгыг олно уу. (1 оноо)
НТӨ III мянганаас Монгол нутгийн уур амьсгал хурдацтай хуурайшиж, эрс тэс болж эхлэв. Энэ үеэс хүмүүс газар тариалан, суурин амьдралаас аажим хөндийрч, эрхлэн амьдрах болжээ.

- А. Үйлдвэрлэх аж ахуй В. Газар тариалан С. Ан агнуур
 D. Бэлчээрийн мал аж ахуй E. Туслах аж ахуй

5. Нүүдэлчдийн байгуулсан анхны төрт улс аль нь вэ? (1 оноо)
 А. Жужан В. Хятан С. Хүннү D. Түрэг E. Сяньби

6. Дараах өгөгдлөөс зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. (2 оноо)

A. Түмэн шаньюй B. Модунь шаньюй	1.	Цинь улсын довтолгоонд өртөв.
	2.	Ордосыг эргүүлэн авав.
	3.	Хань улсын Гаоди хааныг буулгаж авав.
	4.	Хөрш нүүдэлчин улсуудад буулт хийв.

- A. a-1,4, b-2,3 B. a-2,3, b-1,4 C. a-3,4, b-1,2
 D. a-1,2, b-3,4 E. a-1,3, b-2,4

7. Шар мөрөн, Ляоси орчмоор нутаглаж байсан Сяньбийн нэг салбарыг хэрхэн нэрлэх болсон бэ? (1 оноо)
 А. Хүннү В. Хятан С. Жужан D. Түрэг E. Уйгур

8. Хятан аймгууд ба Тан улсын харилцааг зөв тодорхойлсон нь аль вэ? (2 оноо)
 А. Хятан аймгууд ба Тан улс “Энх ургийн гэрээ” байгуулж, хилээ Цагаан хэрмээр тогтоов.
 В. Тан улс, Хятан аймгуудад алба барьж байв.
 С. Хятан аймгууд Тан улсыг түрэмгийлэн захиргаандаа оруулав.
 D. Тан улс, Хятан аймгууд руу 3 жил тутам их цэргээр довтолж, түйвээдэг байв.
 E. Хятан аймгууд, Тан улсын түрэмгийллийн эсрэг тэмцэж, бие даан оршиж байв.




9. Эсгий урлалын арга технологи өндөр хөгжсөнийг харуулах дурсгал Ноён уулын язгууртны булшнаас олдсон нь аль улсын үед холбогдох вэ? (1 оноо)
 А. Хүннү В. Сяньби С. Жужан D. Түрэг E. Уйгур
10. Монгол нутагт оршиж байсан уйгуруудын шашин шүтлэгийг зөв илэрхийлсэн хариултыг сонгоно уу. (1 оноо)
 А. Шива бурхан шүтдэг байв. В. Манихейн шашинтай байв.
 С. Бөө мөргөлтөн байв. D. Хиндү шашинтай байв.
 E. Ману бурхан шүтдэг байв.
11. Дараах сурвалжийн мэдээ нь ямар улсын тухай өгүүлж байна вэ? (1 оноо)
"6390 оны зун. Олег ван их цэргээ авч, аян дайнд мордов... Смоленск хотыг эзлэн авч, өөрийн хүнээр захируулав..."
 А. Зүүн Гот улс В. Вандаул улс С. Франк улс D. Орос улс E. Византын эзэнт улс
12. Майя, Ацтек, Инкийн түүхэнд холбогдох зөв бодомжийг олно уу. (2 оноо)
 А. Ацтекчүүд 60 метр өндөр "Нарны сүм"-ийг байгуулав.
 В. Майячууд Чичен Ица хотыг байгуулав.
 С. Инкүүдийн зохиосон нарны хуанли 4 улиралтай байв.
 D. 1570 онд португалчууд Ацтекийг эзлэн авав.
 E. Майячууд Андын нуруугаар нутаглаж байв.
13. Исламын шашныг үндэслэгч Мухаммедын төрсөн хот аль вэ? (1 оноо)
 А. Медина В. Ясриб С. Антиох D. Иерусалим E. Мекка
14. Тан, Сүн улсуудын түүхэнд холбогдох **А ба Б** жагсаалтад тохирох хариултыг сонгоно уу. (2 оноо)
А. Чанань, Лоян, Бянжин **Б. Ли Ши Мин, Ван Ань Ши**
 А. Нийслэл хот, шинэчлэгчид В. Газар нутаг, цэргийн жанжид
 С. Нийслэл хот, улсыг үндэслэгчид D. Хил хязгаар, түшмэд
 E. Хөрш улсууд, хаад
15. Ираны эзлэн түрэмгийлэгчид 1206 онд Энэтхэгт Дели төвтэй султант улс байгуулжээ. Тус улсын ноёлох хэсэг ямар шашин шүтэж байсан бэ? (1 оноо)
 А. Загалмайтны шашин В. Лалын шашин С. Индус шашин
 D. Шинтогийн шашин E. Бурхны шашин
16. Тохирох утгатай нь зөв харгалзуулсныг дугуйлна уу. (1 оноо)
 1. Камиказе а. Нарны бурхан
 2. Кана б. Бурхны салхи
 3. Аматаэрасу с. Хятад бичигтэй хамт хэрэглэгддэг.
 А. 1с,2а,3b В. 1с,2b,3а С. 1b,2а,3с D. 1b,2с,3а E. 1а,2с,3b
17. XII зууны үеийн Монгол улсын гол аймагт аль нь багтаж байсан бэ? (1 оноо)
 А. Мэргид В. Онгуд С. Хэрэйд D. Татар E. Тайчуд
18. Монгол-Татарын зөрчлийн шалтгааныг зөв тодорхойлсон хариултыг олно уу. (2 оноо)
 А. Байгаль нуур, Баргужин төхөмийн нутгийг булаалдан тэмцэлдсэнээс
 В. Алтан улстай харилцах, худалдаа хийх замд Татар хөндөлсөн оршдогоос
 С. Амбагай хан нас барж, Хадаан тайш хан болсноос
 D. Инанч билгэ хаан таалал төгссөний дараа төрийн эрх мэдлийн төлөө тэмцэлдсэнээс
 E. Маркус хан нас барж, Сарык хан захирах болсноос



19. Адилтгах замаар зөв хариултыг дугуйлна уу. (1 оноо)
Найман-Таян хан **Жадаран-?**
 А. Тогтога В. Тоорил хан С. Жамуха Д. Хутуга бэхи Е. Мэгүжин сүүлт
20. Чингис хаан 1204 онд Наймантай хийсэн тулааны төлөвлөгөөг боловсруулахдаа дайснаа тайвшруулахын тулд ямар арга боловсруулсан бэ? (1 оноо)
 А. Цэрэг бүр олон гал түлсэн В. Зориуд туранхай агт олзлуулсан
 С. Цэргийн гол хүчээ ухраасан Д. Дайсны гол хүч рүү гэнэт довтолсон
 Е. Дайснаа дөрвөн талаас нь бүсэлсэн
21. 1260 онд Кайпин буюу хожмын Шандуд хаан ширээнд хэн суусан бэ? (1 оноо)
 А. Хубилай В. Гүюг С. Аригбөх Д. Мөнх Е. Өгөдэй
22. Их Юань улс нийт хүн амаа дөрвөн зэрэглэлд хуваажээ. Гуравдугаарт ямар хүн ордог вэ? (1 оноо)
 А. Монгол хүн В. Өнгөт нүдтэн хэмээх уйгур, перс, араб
 С. Нанхиад хүмүүс Д. Ази, Европ, Африк
 Е. Умард хятадын зүрчид, хятан
23. Газрын зургийг ажиглаад зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

Алтан ордны үлсын нийслэл Сарай хотын байршлыг хэдийн тоогоор тэмдэглэсэн байна вэ?



- | | | | | |
|--|------------------------|-----------------------|--------------|-----------|
| A. 3 | B. 5 | C. 4 | D. 1 | E. 2 |
| 24. Аюушридар хааны эцэг хэн байсан бэ? | | | | (1 оноо) |
| A. Төгстөмөр | B. Тогоонтөмөр | C. Майдарбал | D. Ринчинбал | E. Хайсан |
| 25. Монголын улсын цэргийн зүүн жигүүрийн жанжин Нагачу 1387 онд Мин улсад дагаж оров. Энэ нь хэддүгээр зууны, хэддүгээр хагаст болсон үйл явдал вэ? | | | | (1 оноо) |
| A. XIII зууны I хагас | B. XIII зууны II хагас | C. XIV зууны II хагас | | |
| D. XIV зууны I хагас | E. XV зууны I хагас | | | |



26. XIV-XVII зууны үеийн Халх Монголд хамаарах өгөгдлүүдээс зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)
- | | | |
|----------------|--------------------------|---------------------------|
| 1. Ашихай | 2. Өврийн 5 отог | 3. Хэрлэн голын сав газар |
| 4. Арын 7 отог | 5. Хатан голын сав газар | 6. Алчүбөлд |
- A. 3,4,6 B. 1,2,3 C. 2,4,5 D. 1,3,4 E. 2,5,6
27. XVII зууны үед Төвөдөд бурхны шашны урсгалууд, номлол сургаалаа дэлгэрүүлэхийн төлөө өрсөлдөж байв. Ямар урсгалуудын хооронд гол өрсөлдөөн өрнөж байсан бэ? (1 оноо)
- A. Суннит, Шийт B. Улаан, Шарын C. Күнз, Дао
D. Хар, Цагаан E. Хинаяна, Махаяна
28. Дараах сурвалжийн мэдээнд хийсэн оновчтой дүгнэлтийг сонгоно уу. (2 оноо)
- 1640 онд баталсан “Их цааз” хуулиас: *“Монгол, Ойрад дор дайсан ирвээс хэл өг. Тэр хэл сонсож байж захын их ноёд эс ирвээс зуун хуяг, зуун тэмээ, мянган адуу авах. Бага ноёд эс ирвээс арван хуяг, арван тэмээ, зуун адуу авах болов...”*
- A. Бага ноёдоос 10 хуяг, 10 тэмээ, 100 адуу авах ёстой гэж заасан
B. Монгол, Ойрадын ноёд хамтран Мин улсыг эзлэн түрэмгийлэх тухай заасан
C. Монгол, Ойрадын ноёд дайны олзоо хуваах тухай заасан
D. Их ноёдоос 100 хуяг, 100 тэмээ, 1000 адуу авах ёстой гэж заасан
E. Харийн түрэмгийлэгчдийн эсрэг Монгол, Ойрадын ноёд хамтран тэмцэх тухай заасан
29. Монголчуудын мод, зэс, хорголж, төмөр зэргийг ашиглан номыг олон тоогоор хэвлэх аргыг юу гэдэг вэ? (1 оноо)
- A. Барлах B. Хуулан бичих C. Дүрслэх
D. Үйсэн дээрх бичих E. Орчуулан бичих
30. XVI-XVII зууны үед монголчуудын мал сүрэг өсөж, нутаг бэлчээрт хүндрэл гарснаар хэрхэн нүүдэллэх болсон бэ? (1 оноо)
- A. Хороогоор B. Хот айлаар C. Хүрээгээр D. Отгоор E. Хошуугаар
31. 1804 онд анхны төмөр замын зүтгүүрийг хэн зохион бүтээсэн бэ? (1 оноо)
- A. Сирьюс Хол МакКормик B. Орвил Райт C. Ричард Трэвитик
D. Жорж Стефенсон E. Вилбур Райт
32. Улс төр, эдийн засгийн эрх мэдлээ бусад улсад бүрэн алдсан орныг юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
- A. Хараат орон B. Колони орон C. Хагас колони орон
D. Эзлэгдсэн орон E. Буурай хөгжилтэй орон
33. **А ба Б** жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ? (2 оноо)
- | | |
|---|--|
| А. Египет, Судан
A. Герман, Италийн колониуд
C. Итали, Бельгийн колониуд
E. Англи, Францын колониуд | Б. Камбож, Баруун ба экваторын Африк
B. Герман, Францын колониуд
D. Нидерланд, Францын колониуд |
|---|--|
34. Австралийн далайн эрэг меланези, полинези, микронези гэсэн мужуудад хуваагдана. Меланези мужийн оршин суугчид ямар хэв маягтай байсныг тодорхойлно уу. (2 оноо)
- A. Монголиод хэв маягийн цагаан арьстай, шулуун үстэй.
B. Негроид хэв маягийн хар арьстай, буржгар үстэй.
C. Европиод хэв маягийн цагаан арьстай, буржгар үстэй.
D. Негроид хэв маягийн биерхүү өндөр, саарал нүдтэй.
E. Европиод хэв маягийн шаргал үстэй, цэнхэр нүдтэй.



35. Газар доор урт хонгил ухаж, төмөр зам тавьснаар олон хүнтэй хотууд түргэн хямд тээврийн хэрэгсэлтэй болов. Анхны метро ямар хотод баригдсан бэ? (1 оноо)
 А. Лондон В. Парис С. Москва D. Берлин E. Милан
36. XIX зууны үед Италийн “Ла Фенече”, Их Британийн Лондон хотын “Колизеум зэрэг гоёмсог театрууд баригдсаны ач холбогдлыг олно уу. (2 оноо)
 А. Бүжгийн урлаг хөгжихөд нөлөөлсөн
 В. Уран зохиол хөгжихөд түлхэц болсон
 С. Кино урлаг хөгжих эхлэл тавигдсан
 D. Дуурийн урлаг өндөр хөгжих эхлэл болсон
 E. Уран бүтээлчид романтизмын чиглэлээр бүтээл туурвих болсон
37. Өвөр Монголын ноёд Мүгдэнд, Манжийн хааныг эзэн хаанаа хэмээн зөвшөөрчээ. Энэ үйл явдлаас 119 жилийн дараа Манжийн эрхшээлд орсон улсыг дугуйлна уу. (1 оноо)
 А. Халх Монгол В. Зүүнгар улс С. Хөх нуурын Монгол
 D. Буриад Монгол E. Халимаг
38. 1648 онд Байгаль нуурын зүүн талд оросуудын байгуулсан шивээг дугуйлна уу. (1 оноо)
 А. Нэрчү В. Эрхүү С. Баргужин D. Балганск E. Братск
39. 1691 онд дотоод задралын улмаас тусгаар байдлаа алдсан нь аль вэ? (1 оноо)
 А. Өвөр Монгол В. Халх Монгол С. Зүүнгар D. Хошууд Монгол E. Буриад Монгол
40. Дараах үйл явдлуудаас Халх Монгол Манжид эзлэгдсэн дотоод шалтгааныг олно уу. (1 оноо)
 А. Оросын зүгээс Халимагийн дотоод хэрэгт оролцох болов.
 В. Хорчины Ууба тайж Манжийн хаантай ураг барилдав.
 С. Байгаль нуурын зүүн талд Түнхэн шивээ байгуулагдав.
 D. Түшээт хан, Засагт хан руу довтлов.
 E. Манжийн цэрэг Сөнөдийн Тэнгис ванг нэхэж Халхад оров.
41. Амарсанаагийн бослогод холбогдох үйл явдлыг сонгоно уу. (1 оноо)

Зүүнгарын Амарсанаагийн бослого	1	Орос улс руу зугтаж гарсан
	2	Газар, түрээслэх худалдаалахыг эсэргүүцсэн
	3	Өртөө, харуул, цэргийн албыг хаяж явсан
	4	3000 цэргээ удирдан Манжтай байлдсан

А. 2,3 В. 1,3 С. 3,4 D. 2,4 E. 1,4

42. Жирмийн чуулганы Горлос хошууны Тогтох тайж Манжийн эсрэг зэвсэгт бослого гаргасан шалтгаан нь юу вэ? (2 оноо)
 А. Хятад иргэд бэлчээр нутгийг булаан тариа тарин суурьших болсон тул
 В. Ихэтуаны бослогыг Монгол цэргээр дарахыг эсэргүүцсэн тул
 С. Халх Монголд хятадын мөнгө хүүчлэгч, худалдаачдын мөлжлөг хэрээс хэтэрсэн тул
 D. Монголчуудаас авах Манжийн алба татвар нэмэгдсэнийг эсэргүүцсэн
 E. Зүүнгарын монголчуудыг олон арван мянгаар нь хядсанд
43. 1911 онд үндэсний хувьсгал ялсны дараа оны цолыг хэрхэн нэрлэсэн бэ? (1 оноо)
 А. Бүгд найрамдах В. Олноо өргөгдсөн
 С. Монгол улсын D. Тусгаар тогтносон E. Мандан бадарсан




44. Түүхэн үйл явдлыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсан хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. “Харилцан туслах хоршоо” байгуулав.
2. “Монгол улсын хязгаарын доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм хэмжээ”-г батлав.
3. “Нийслэл хүрээний сонин бичиг”-ийг хэвлэв.

A. 1,2,3 B. 3,1,2 C. 2,3,1 D. 2,1,3 E. 1,3,2

45. Он тооллын шугамыг ажиглан тохирох хариултыг сонгоно уу. (1 оноо)



- A. Нийслэл хүрээг чөлөөлөх шийдвэр гаргав. B. Д.Сүхбаатарыг цэргийн жанжнаар томилов.
 C. Хиагт хотыг чөлөөлөв. D. Нийслэл Хүрээнд нууц бүлгэм байгуулагдав.
 E. Ардын Засгийн Газар байгуулагдав.

46. Хүснэгтийг ажиглан “**Тангарагийн гэрээ**”-нд хамаарах зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Он цаг	2. Үүрэг	3. Үр дүн
a. 1922 оны 1 сарын 5	a. Бодлого, шийдвэр боловсруулах, Засгийн газарт зөвлөх	a. Үндсэн хуулийн үүргийг гүйцэтгэж байсан.
b. 1921 оны 11 сарын 1	b. Эзэн, хамжлагын харилцааг зохицуулах	b. Ноёд эрх мэдлээ алдсан.
c. 1922 оны 5 сарын 22	c. Богд хаан ба Ардын засгийн газрын хоорондын харилцааг зохицуулах	c. Нийгэм, эдийн засгийн хүрээнд ардчилсан өөрчлөлт гарсан.

A. 1b,2c,3a B. 1a,2c,3b C. 1c,2a,3b D. 1c,2b,3b E. 1a,2a,3b

47. Улсын анхдугаар Их Хурлаар шийдвэрлэсэн хамгийн гол асуудал юу вэ? (1 оноо)

- A. Хамжлагат ёсыг халах шийдвэр гаргасан
- B. Үндсэн хуулийг батлан тогтоосон
- C. Бүх нийтийн сонгуулийн эрхийг баталсан
- D. Нийслэлийн нэрийг өөрчилсөн
- E. Үндсэн хууль боловсруулах комисс байгуулсан

48. Зүүнтний алдаатай бодлогоор 1932 онд 16 сая болсон мал сүргийн тоо Шинэ эргэлтийн бодлогын үр дүнд 1940 он гэхэд хэдэн хувиар өссөн бэ? (1 оноо)

A. 5,6% B. 39.1% C. 20,8% D. 12,8% E. 27,6%



49. 1932 оны 5 сард ЗХУ-д хуралдсан Бүх Холбоотны Коммунист намын Төв хорооны Монголын талаар тусгай тогтоол гарав. Уг тогтоолд хамаарах агуулгыг зөв ялгасан хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг бүдүүлгээр зөрчсөн
2. Ардын аж ахуйтны мал сүргээс хураах албан татварыг хөнгөвчилсөн
3. Монголд ЗХУ-ын социализм байгуулах үйл ажиллагааг шууд хуулбарласан
4. Чинээлэг аж ахуйтанд зээл олгодоггүй байсан журмыг халсан
5. Ардын сүсэг бишрэлийг доромжилсон

A. 2,3,5

B. 2,3,4

C. 1,3,5

D. 3,4,5

E. 1,2,4

50. Чөлөөлөх дайнд Монгол ардын хувьсгалт цэргийн анги нэгтгэл Өвөр байгалийн фронтын баруун жигүүр болж, ямар чиглэлээр давшин байлдсан бэ? (1 оноо)

- A. Мүгдэн, Хайлаар-Харбин B. Хайлаар, Харбин-Жэхэ C. Гирин, Мүгдэн-Долоннуур
D. Чуулалт хаалга, Харбин-Гирин E. Чуулалт хаалга, Долоннуур-Жэхэ

51. Монголын ардчилсан нам эмхлэн байгуулагдсаныг хэдэн онд зарласан бэ? (1 оноо)

A. 1991

B. 1990

C. 1992

D. 1989

E. 1993

52. Монголын ардчилсан холбоо хэзээ, ямар үйл явдлаар байгуулагдсан бэ? (2 оноо)

- A. 1990 оны 3 сарын 7-ны өдөр, Сүхбаатарын талбайд зарласан өлсгөлөнгөөр
B. 1989 оны 12 сарын 3-ны өдөр, Залуу уран бүтээлчдийн II зөвлөгөөнөөр
C. 1990 оны 3 сарын 12-14-ны өдөр, МАХН-ын бүгд хурлаар
D. 1989 оны 12 сарын 10-ны өдөр, МоАХ-ны анхны цуглаанаар
E. 1990 оны 4 сарын 27-ны өдөр, Ялалтын талбайд болсон цуглаанаар

53. Тохирох утгатай нь зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. (2 оноо)

1.	Улсын бага хурлын дарга	a.	П.Очирбат
2.	Ерөнхий сайд	b.	Р.Гончигдорж
3.	Ерөнхийлөгч	c.	Д.Бямбасүрэн

A. 1c,2a,3b

B. 1b,2c,3a

C. 1c,2b,3a

D. 1b,2a,3c

E. 1a,2c,3b

54. Хэдэн оноос эхлэн 9 дүгээр сарын 10-ны өдрийг улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгосон бэ? (1 оноо)

- A. 2010 он B. 1992 он C. 2003 он D. 2007 он E. 1996 он

55. Дараах өгөгдлөөс 1990 оны хувьсгалын үр дүнд оюун санааны хүрээнд гарсан өөрчлөлт аль нь вэ? (2 оноо)

- A. Монгол Улс олон намын тогтолцоонд шилжиж, парламентын засаглалтай болов.
B. Чингис хааны мэндэлсэн өдрийг “Монгол бахархлын өдөр” болгон тэмдэглэх болсон
C. Анхны чөлөөт ардчилсан сонгууль явагдаж, Монгол улс ерөнхийлөгчтэй болов.
D. Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт эдийн засагт шилжсэн
E. Монгол Улс шинэ Үндсэн хуулиа баталж, өнөөгийн ардчилсан тогтолцоо бий болов.

56. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал” гэдэг тодорхойлолтыг сонгоно уу. (2 оноо)

- A. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс гэж үзсэн байна.
B. Эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.
C. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ.
D. Монгол төрийн залгамж чанарыг бэхжүүлэх, дотоод аюулгүй байдлыг хэлнэ.
E. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны цогцыг бататган бэхжүүлэхийг хэлнэ.



Хоёрдугаар хэсэг

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай, тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо. Даалгавруудын хариултыг бөглөхдөө хариултын хуудасны 2-р хэсгийг бөглөх заавартай сайтар танилцаарай.

2.1 Их Монгол улсын төр, засаг захиргааны бүтэц ба албан тушаалтнуудыг зөв харгалзуулна уу. (6 оноо)

a. Чингис хааны дөрвөн нохос	1. Мухали
b. Их заргач	2. Зэв
c. Зүүн түмний захирагч	3. Үсүн өвгөн
d. Төрийн бэхи	4. Шихихутуг
e. Чингис хааны дөрвөн хүлэг	5. Боорчу
f. Баруун түмний захирагч	6. Чулуун

2.2 Эрдэмтдийг шинжлэх ухааны ололт, нээлтүүдтэй нь зөв тохируулна уу. (6 оноо)

a. Майкл Фарадей	1. “Зүйлийн үүсэл” хэмээх алдарт бүтээлээ гаргав.
b. Чарлз Дарвин	2. Механик ургац хураагч нь гурван хүний ажил гүйцэтгэдэг байв.
c. Жозеф Листер	3. Анхны нисэх онгоцыг зохион бүтээв.
d. Орвил, Вилбур Райт	4. Мэдээллийг радио долгионоор дамжуулах утсан шугамгүй телеграфын санал гаргав.
e. Сирьюс Хол МакКормик	5. Бактерийн эсрэг карболын хүчлийг мэс засалд ашиглав.
f. Гульельмо Маркони	6. Эфирийн химийн нэгдэл өвдөлт зогсоодог нээлт хийв.

2.3 БНМАУ-ын нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтийг холбогдох ойлголттой нь зөв тохируулна уу. (6 оноо)

a. Х.Чойбалсан	1. Үзэл суртлын хатуу шалгуур бий болсон
b. Авторитар дэглэм	2. Хөдөө аж ахуйг шинээр зохион байгуулсан
c. Пролетарийн интернационалч зарчим	3. Нэг үзэл суртлыг тунхаглаж, хувийн өмчийг үгүйсгэн нийтийн өмчийг тулгах болсон
d. Нэгдэлжих хөдөлгөөн	4. Төр нийгмийг удирдан чиглүүлэх цорын ганц хүч бол МАХН мөн.
e. Атрын I аян	5. Хууль ёсыг ноцтой зөрчиж үй олон хүнийг хэлмэгдүүлсэн
f. Хүнд суртлын тогтолцоо	6. Ургацын хэмжээнд бус талбайн хэмжээнд анхаарсан

2.4 БНМАУ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын хөгжилд гар өөрчлөлтийг холбогдох ойлголттой нь зөв тохируулна уу. (6 оноо)

a. 1961 он	1. Н.Курпскаягийн нэрэмжит шагнал авав.
b. 1970 он	2. Шинжлэх ухааны академи өөрчлөн байгуулагдав.
c. 1972 он	3. Сургуулийн бүтцийг 3+5+2 болгов.
d. 1981 он	4. Мандухай сэцэн хатан кино дэлгэцнээ гарав.
e. 1984 он	5. Лос-Анжелосын Олимпын тоглолтыг өнжив.
f. 1988 он	6. Монгол хүн сансарт нисэв.

